

УЛААНБААТАР ХОТЫН МУЗЕЙН ТОВЧ ТҮҮХ

Нэг.БАЙГУУЛЛАГЫН ТҮҮХ

Эх орны маань нэрийн хуудас, нийслэл Улаанбаатар хотын түүхэн замнал, хөгжил дэвшлийг нийслэлийн иргэд, зочид гийчдэд таниулах зорилгоор тус музейн анхны суурь 1956 онд “Улаанбаатар хотын түүхийн үзэсгэлэн” нэртэйгээр байгуулагджээ. Үзэсгэлэнг анх 1956 оны 7-р сарын 9-нд нээхэд Улаанбаатар хотын захиргааны дарга Ламжав үг хэлж тууз хайчилсан бөгөөд Намын Төв хорооны дарга Дамба оролцсон байна. Музей анх байгуулагдахад дарга Рагчаасүрэн, коминдат Даш гэсэн хоёр орон тоотойгоор ажиллаж эхэлжээ.

МАХН-ын Төв хорооны Улс төрийн товчооны 1960 оны 4-р сарын 11-ний өдрийн 106-р тогтоолоор “Хотын түүхийн үзэсгэлэн”-г “Улаанбаатар хотын Түүх, Шинэчлэн байгуулалтын музей” болгон өргөтгөхөд түүхч Х.Пэрлээ, зураач Ү.Ядамсүрэн нар идэвхитэй оролцож, зураач Ү.Ядамсүрэн үзмэр зохион байгуулах эскизийг хийж, түүхч Х.Пэрлээ үзмэр дэглэлтийг зохион байгуулж хийсэн байна. 1961 оны 7-р сарын 9-нд тус музейг нээхэд музейн дарга Лувсанцэрэн, Улаанбаатар хотын захиргааны хариуцлагатай нарийн бичгийн дарга Донров, Сүхбаатар хорооны дарга, музейн ажилчид, хороодын иргэд оролцжээ. Музейг шинээр байгуулахтай холбогдож 1960 онд СнЗ-ийн тогтоолоор музейн орон тоо, цалинг нэмж тайлбарлагч 2, фото зурагчин 1, манаач 2-ийг нэмж батлан нийт 12.5 орон тоотойгоор ажиллуулсан байна.

Тус музейн ажиллах хугацаанд “Улаанбаатар хотын түүхийн үзэсгэлэн”-ийн даргаар Рагчаасүрэн, 1960 оноос “Улаанбаатар хотын Түүх, Шинэчлэн байгуулалтын музей”-н даргаар Лувсанцэрэн, 1962 оноос Н.Дүрзээ, 1977 оноос Цагаач, 1987 оноос музейн захирлаар М.Мижидгомбо, 1992 оноос Б.Бизъяа, 2005 оноос Б.Болдбаатар, 2011 оноос Улаанбаатар хотын музейн захирлаар С.Цацралт ажиллаж байна.

Улаанбаатар хотын музей нь Улаанбаатар хотын түүхэн хөгжлийн үечлэлээр нь Нүүдлийн Өргөө, Их хүрээний үе /1639-1778 он/, Их хүрээ хот /1778-1911 он/, Нийслэл хүрээний үе /1911-1924 он/, Улаанбаатар хотын үе /1924-1990 он/, /1990 оноос хойш/ хэмээн хуваан үзэж, үзүүллэгийн гурван танхимаар үзмэрээ дэлгэн үзүүлдэг. Тус музей анх байгуулагдсан 1956 оноос хойш 1960, 1971, 1974, 1995, 2011 онуудад нийт 5 удаа үзүүллэгийн зохион байгуулалтыг шинэчилсэн.

Өнөө музейн сан хөмрөг 3300 гаруй үзмэртэйгээс үзүүллэгийн танхимд нийт үзмэрийн гуравны нэг нь тавигдаж үзэгчдийн хүртээл болж байна. Музейн сан

хөмрөг дэх үзмэрийн онцлох заримаас сонирхуулвал, нэрт зураач Манибадар 1946 онд зурсан “Нийслэл хүрээ” зураг, Төрийн соёрхолт, Гавъяат сийлбэрчин Д.Сэнгээгийн “Түүхт Улаанбаатар” зааны соёон сийлбэр, 1976-2000 он хүртэл Улаанбаатар хотыг хөгжүүлэх III ерөнхий төлөвлөгөө, Туул голын орчмоос олдсон 5 сая жилийн тэртээ амьдарч байсан Арслан зааны яс, XIX-XX зууны үед Их хүрээний урчууд урласан өвөрмөц хийц, загвар бүхий гэр ахуй, гоёл чимэглэлийн зүйлүүд мэтсийг энд дурдаж болно.

Эдүгээ тус музей бүтэц, орон тоо, зохион байгуулалтын хувьд захирал, бүртгэл мэдээллийн санч-дотоод ажил хариуцсан мэргэжилтэн, эрдэм шинжилгээний ажилтан, тайлбарлагч, сан хөмрөгч, дизайнер, зохион байгуулагч-үйлчлэгч, ня-бо, дөрвөн жижүүр нийт 12 орон тоотойгоор ажиллан үйл ажиллагаа явуулж байна.

Хоёр. ХӨМРӨГИЙН БАРИМТЫН ТҮҮХ

Улаанбаатар хотын Түүх, Шинэчлэн Байгуулалтын музей нь 1956 онд анх “Түүхийн үзэсгэлэн” нэртэйгээр байгуулагдаж, 1960 онд Улаанбаатар хотын Түүх, Шинэчлэн Байгуулалтын музей болон өргөжсөн.

Музей нь 2002 онд 1970-2002 он хүртэлх архивын баримтын Нийслэлийн архивын газарт шилжүүлсэн. Үүнд: Байнга хадгалах 20 хадгаламжийн нэгж бүрдүүлэн өгсөн байна.

Тус музейн Архив, бичиг хэргийн ажилтан Ч.Өсөхжаргал нь 2003-2005 оны баримтыг үдэж цэгцэлснээр 11 хадгаламжийн нэгж бий болж, 2006 онд 6 хадгаламжийн нэгж, 2007 онд 6 хадгаламжийн нэгж үүсгэн, нийт 40 хадгаламжийн нэгж байгууллагын архивт бий болсон байна.

2008 оны X сараас байгууллагын архив, бичиг хэргийн ажилтнаар Г.Очбаяр томилогдон ажиллав.

Монгол улсын Ерөнхий сайдын 2009 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 37 тоот “Улсын үзлэг явуулах тухай” захирамж гарсантай холбогдуулан, улсын үзлэгт бэлтгэх ажлын төлөвлөгөө гарган байгууллагын архивыг цэгцэлсэн байна. Үүнд: өмнөх хадгаламжийн нэгжүүд нь архивын заавар, журмын дагуу хийгдээгүй байсан тул тэдгээр баримтыг задалж, хадгаламжийн нэгжийг шинээр бүрдүүлсэн байна. Үүнд:

- Баримт бичгийг он, зохион байгуулалтын ач холбогдлоор нь төрөлжүүлэн ангилсан
- Байнга, түр, 70 жил хадгалахаар цэгцэлсэн

- Байнга хадгалах хадгаламжийн нэгжийн хуудас дугаарлан үдэж хавтаслах, баталгаа бичих, нуруу цаас наах, хадгаламжийн нэгжид дугаар өгөх зэрэг ажлуудыг хийсэн.

Үүнд:

Түр хадгалах хадгаламжийн нэгжид 2002 онд 1, 2003 онд 5, 2004 онд 4, 2005 онд 10, 2006 онд 17, 2007 онд 16, 2008 онд 17, 2009 онд 28, 2010 онд 31, 2011 онд 30, **/Нийт 139/**

Байнга хадгалах хадгаламжийн нэгжид 2001 онд 1, 2002 онд 1, 2003 онд 2, 2004 онд 4, 2005 онд 14, 2006 онд 8, 2007 онд 10, 2008 онд 11, 2009 онд 22, 2010 онд 19, 2011 онд 14 хадгаламжийн нэгж. **/Нийт 96/**

Удаан хугацааны хадгаламжийн нэгжид 2002 онд 1, 2003 онд 1, 2004 онд 1, 2005 онд 1, 2006 онд 1, 2007 онд 1, 2008 онд 1, 2009 онд 2, 2010 онд 4, 2011 онд 3, **/Нийт 16/** хадгаламжийн нэгж тус тус үйлдсэн байна. Нийт хадгаламжийн нэгжийн тоо 251. Эдгээр хадгаламжийн нэгжийг тавиур дээр байрлуулан оны заагуурыг хийж цэгцэлсэн байна.

2012 оны 10 сард Тайлбарлагч Д.Оргил нь архив, бичиг хэргийн ажлыг Г.Очбаяраас хүлээн авсан. 2012, 2013 оны баримтуудыг Байгууллагын архивын заавар журмын дагуу бүрдүүлэн хүлээн авсан.

Үүнд:

- Түр хадгалах хадгаламжийн нэгж 2012 онд 18, 2013 онд 16 хадгаламжийн нэгж
- Байнга хадгалах хадгаламжийн нэгж 2012 онд 13, 2013 онд 19 хадгаламжийн нэгж
- Удаан хугацааны хадгаламжийн нэгж 2012 онд 3, 2013 онд 3 хадгаламжийн нэгжийг бүрдүүллээ.

Нийт байгууллагын архивт түр хадгалах 74 хадгаламжийн нэгж, байнга хадгалах 35 хадгаламжийн нэгж, удаан хугацаагаар хадгалах 7 хадгаламжийн нэгж нийт 116 хадгаламжийн нэгж үүссэн байна.

2014 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн ББНШАЗК-ын хурлаар 2002-2009 оны байнга хадгаламжийн нэгжийн баримтуудыг төрийн архивт шилжүүлэх талаар хэлэлцлээ. Мөн музейн үндсэн үйл ажиллагааны чиглэлийг харуулсан музейн үзмэр, эд өлгийн зүйлийн ерөнхий бүртгэлийн 2001 оны 1, 2008 оны 3 дэвтэр, 2008 оны сан хөмрөгийн улсын тооллогын тайланг зэрэг баримтыг данс бүтгэлд нэмж дансыг 2002-2009 он хүртэл үйлдэж данс хоёр болгон үйлдхээр шийдвэрлэв.